

**МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТУХАЙ
ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН
МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 10 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Монгол Улсын Их Хурлаас батлан гаргасан хууль, тогтоомжийн хүрээнд мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тогтолцоог бүтээн байгуулалтын томоохон зорилттой уялдуулах, чанар, үр дүн, гүйцэтгэлд суурилсан олон эх үүсвэр бүхий санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажлын байрны шаардлагад нийцсэн мэргэжилтэн бэлтгэхийн тулд сургалтын агуулга, хөтөлбөрт шинэчлэл хийж, ажил олгогч, мэргэжлийн холбоодын оролцоог нэмэгдүүлснээр нийгмийн түншлэлийг бэхжүүлэх, сургалтын уян хатан хэлбэрийг хүлээн зөвшөөрөх зэрэг хэрэгцээ, шаардлагын үүднээс хуулийн төслийг боловсруулжээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан хуулийн заалт хоорондын уялдаа холбооны талаар, бүх шатны боловсролын байгууллагын багш, ажилтны мөнгөн тэтгэмж ижил байгаа эсэх, салбарын онцлогоос хамаарч хүүхэд хамгааллын талаарх зохицуулалтыг тусгасан эсэх, мэргэжлийн ёс зүйн асуудлыг хэрхэн тусгаж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа хуулийн төсөлд ажил мэргэжлийн стандарт хэрхэн туссан, Дээд боловсролын тухай хуультай нэр томъёоны тодорхойлолт нийцэж байгаа эсэх, хувийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын байгууллагыг хэрхэн дэмжиж байгаа болон суралцагчийн тэтгэлгийн талаар асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал төрийн болон хувийн өмчийн аж ахуйн нэгжүүдэд мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага байгуулах эрх олгох, техник технологи, цахим хөгжлийн чиглэлээр дагнасан сургууль байгуулах талаар, сургуулийн захиралд нарийвчилсан хатуу шаардлага тавилгүй, нээлттэй уян хатан байх талаар санал хэллээ.

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон

гишүүдийн олонх дэмжиж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Г.МӨНХЦЭЦЭГ